



Бурхан бол Мэргэн юм Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Мэргэн юм

Attribute: God Is Wise

Тодорхойлолт: Ялгах ухаан, ойлгох ухаан, мэдлэгээр дүүрэн Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Иов 12:13** Мэргэн ухаан хийгээд хүч Түүнтэй хамт байх бөгөөд Зөвлөгөө хийгээд ухаарал Түүнд харьяалагддаг.
- **Иеремиа 10:12** Хүч чадлаараа дэлхийг бий болгож, Мэргэн ухаанаар ертөнцийг тогтоосон Тэр билээ. Түүний ухаанаар тэнгэрс тэлсэн билээ.
- **Ром 11:33** Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь юутай гүн бэ! Түүний шүүлтүүд нь ямар ойлгож баршгүй, Түүний замууд нь ямар олж илрүүлшгүй вэ?
- **Иаков 1:5** Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно.
- **Иаков 3:17** Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, үл суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Сургаалт үгс 4:11; Иаков 3:17

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр)—ийг мэргэн ухааны арга замаар удирдан дагуулж цэх шулуун жимээр алхуулаач.

(Хүүхдийн нэр) маань өөрийн амьдралдаа дээрээс ирдэг цэвэр ариун, амар амгалан, эелдэг, үл суурьтай, өршөөл ба сайн үйлсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүргүй чин үнэнч мэргэн ухаанаар амьдрах болтугай.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____-ийг мэргэн ухааны арга замаар удирдан дагуулж цэх шулуун жимээр алхуулаач. _____ маань өөрийн амьдралдаа дээрээс ирдэг цэвэр ариун, амар амгалан, эелдэг, үл суурьтай, өршөөл ба сайн үйлсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүргүй чин үнэнч мэргэн ухаанаар амьдрах болтугай.
Сургаалт үгс 4:11; Иаков 3:17

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!